



“ АРИГ ГАЛ “  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар  
сарын 21- ны өдөр

Дугаар 08 /24

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”- ийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот,Хан-Уул дүүргийн 19-р хороо,Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсох ;

2.2 Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.3 Компанийн 2024 оны санхүүгийн тайлан балансад аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийг танилцуулах

2.4. 2023 оны үр дүнгээр зарласан ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулах

2.5. Компанийн 2024 оны үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдэд НА тараахаар ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулах

2.6 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.7 2024 оны үйл ажиллагааны ашгаас ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллыг хэлэлцэж батлах

2.8 2025 оны компанийн удирдлагын үйл ажиллагааны зардлын төсөвийг хэлэлцэж батлах

2.9 Компанийн хувьцаанаас КТХ-д заасан хувь хэмжээнд багтаан хадлааслах зөвшөөрөл олгох

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ариг гал ХК-ийн Тэргүүн дэд захирал А.Төмөрчирыг, тооллогын комиссын даргаар П.Цэрэночирыг томилсугай.

4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-д мэдэгдэх өдрийг 2025 оны 3 дугаар сарын 24-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр зарлах өдрийг 2025 оны 3 дугаар сарын 24 болон 4 дүгээр сарын 10-ны өдрүүдээр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.

6. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын танилцуулгыг компанийн цахим хаягт байршуулан нийтэд хүргэх, брокерий н компаниудаар тараах материалыг 2025 оны 3 сарын 28 дотор хүргүүлэх, эхний болон давтан зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэн, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисс (А.Төмөр очир)-т даалгасугай.

7. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер диллерийн компаниуд дээр бэлэн байлгах, Имайлаар хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулахыг, Хурал зохион байгуулах комисс (А.Төмөр очир)-т үүрэг болгосугай.

Үүнд:

- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
- 7.2. 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тадлаарх гүйцэтгэх захирлын тайлан
- 7.3. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гаргах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, компанийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;
- 7.4. Хурлын санал хураах хуудасны загвар.
- 7.5. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга, Нэр дэвшүүлэх хорооны тогтоол
- 7.6. Компанийн удирдлагын зардлын 2025 оны зардлын төсөв
- 7.7. Хувьцаа эзэмшигчдэд 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлын 06/24 тоот тогтоол
- 7.8. 2024 оны үйл ажиллагааны ашгаас ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллыг төсөл
- 7.9. Компанийн хувьцаанаас КТХ-д заасан хувь хэмжээнд багтаан хадлааслах зөвшөөрөл олгох
- 7.10. Хурлаас гаргах шийдвэрээр гаргах тогтоолын төслүүд
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү тогтоолын

Хавсралт №1-ээр баталсугай.

9. Санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг, хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /А.Төмөр очир/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Б.БОЛД

Б.АЮУШ

Э.БЯМБАЖАВ

З.СҮХБААТАР

С.АЛИМАА

Б.ЁНДОНЖАМЦ

Х.МӨНХТУЯА